



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-аас Монгол Улсын Иргэний нисэхийн салбарын үйл ажиллагаанд хийх аюулгүй ажиллагааны өргөтгөсөн аудит шалгалт 2017 оны 08 дугаар сард болохтой холбогдуулан ТУШААХ нь:

1. ИКАО-аас хийх аудит шалгалтанд бэлтгэх, эрх зүйг боловсронгуй болгох, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны протокол асуулгад хариулах, хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ахлагч:	Х.Наранхүү	Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч
Гишүүд:	М.Баатаржав	Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч
	О.Бат-Орших	Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч
	Б.Чинзориг	Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

2. ИКАО-ийн аудит шалгалтын координатор /Continuous monitoring coordinator/-оор тус албаны шинжээч Б.Чинзоригийг томилсугай.

3. ИКАО-аас хийх аудит шалгалтанд бэлтгэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН

